БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

## ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/113/СТА-ТШЗ

---


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Алтантуяа

Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn



Баянхонгор
2021 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 10
3.Аудитын тайлан ..... 10
3.1. Ерөнхий зүйл ..... 10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ..... 11
3.4. Материаллаг байдал ..... 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 13
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
3.9. Аудитын илрүүлэлт ..... 14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 15
4. Менежментийн захидал ..... 15
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 17



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.25 № 2/141

танай ______ -ны № ______ -т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ӨНӨРБАЯР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус байгууллага нь ковид-19 цар тахал онцгой дэглэмийн үед аймаг, сумын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

005020114

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **88,194,729.00** | **88,106,598.00** |
| **33** | **АВЛАГА** | 5,275.00 | 25,994.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,275.00 | 25,994.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 88,189,454.00 | 88,080,604.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 56,079,474.00 | 56,068,124.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,239,589.00 | 1,448,479.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 38,323,185.00 | 38,033,985.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 727,400.00 | 727,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,789,300.00 | 15,858,260.00 |
| 35600 | Мал амьтад | 32,109,980.00 | 32,012,480.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,256,537,192.84** | **1,240,571,676.61** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,256,537,192.84 | 1,240,571,676.61 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,155,225,192.84 | 1,139,259,676.61 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 761,673,169.15 | 761,673,169.15 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -67,966,971.82 | -107,560,490.11 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 166,120,800.00 | 206,120,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -108,634,182.10 | -128,838,046.41 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 156,870,111.13 | 161,782,621.13 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -86,013,196.48 | -110,650,370.24 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,981,750.00 | 55,981,750.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,425,339.99 | -40,915,216.70 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 194,620,000.00 | 194,620,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -59,897,000.26 | -72,428,000.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 325,046,130.00 | 403,246,130.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -143,150,076.79 | -183,772,669.95 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 101,312,000.00 | 101,312,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 101,312,000.00 | 101,312,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,344,731,921.84** | **1,328,678,274.61** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,013.00** | **3,073.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,013.00 | 3,073.00 |
| 413 | **Өглөг** | 1,013.00 | 3,073.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 3,060.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1,013.00 | 13.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,013.00 | 13.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,344,730,908.84** | **1,328,675,201.61** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,344,730,908.84 | 1,328,675,201.61 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 545,016,013.96 | 545,016,013.96 |
| 51101 | Өмч: - төрийн | 545,016,013.96 | 545,016,013.96 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 707,442,612.40 | 691,386,905.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 707,442,612.40 | 707,442,612.40 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -16,055,707.23 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 92,272,282.48 | 92,272,282.48 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,344,731,921.84** | **1,328,678,274.61** |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨВШИЛЦСӨН ТАЙЛАН

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **628,393,480.39** | **532,882,162.74** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **300,878,680.39** | **153,631,970.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 300,878,680.39 | 153,631,970.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 300,878,680.39 | 153,631,970.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,870,396.26 | 2,285,400.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 2,000,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 293,008,284.13 | 151,346,570.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **327,514,800.00** | **379,250,192.74** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,760,000.00 | 10,926,492.74 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,760,000.00 | 3,894,669.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 7,031,823.74 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 321,754,800.00 | 368,323,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 321,754,800.00 | 368,323,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **476,781,462.98** | **548,937,869.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **476,781,462.98** | **548,937,869.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 451,165,791.72 | 530,762,786.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 177,655,688.00 | 206,936,019.00 |
| 210101 | Үндсэн цалин | 177,655,688.00 | 206,936,019.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,332,635.00 | 26,418,344.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,220,879.00 | 17,593,807.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,628,126.00 | 2,206,084.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,588,081.00 | 1,598,423.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 352,333.00 | 417,444.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,543,216.00 | 4,602,586.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,054,531.00 | 53,243,314.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,299,731.00 | 6,265,314.00 |
| 210302 | Түлш, халаалт | 49,754,800.00 | 46,978,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,751,420.00 | 34,409,660.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,807,400.00 | 4,224,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,575,220.00 | 22,477,520.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 895,000.00 | 1,138,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 156,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 173,800.00 | 811,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 5,601,180.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,973,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,973,500.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,354,000.00 | 1,342,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,854,000.00 | 1,342,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 4,500,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,741,565.00 | 22,622,943.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,119,565.00 | 19,020,743.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 18,000.00 | 17,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 318,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,267,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 137,302,452.72 | 185,790,506.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,325,560.00 | 44,512,480.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,800,000.00 | 200,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 114,176,892.72 | 141,078,026.23 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 25,615,671.26 | 18,175,083.55 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,790,700.00 | 12,140,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,590,700.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 12,140,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,824,971.26 | 6,035,083.55 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,706,477.00 | 3,459,419.81 |
| 213404 | Хөрөнгийн | 1,118,494.26 | 2,575,663.74 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 151,612,017.41 | -16,055,707.23 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 151,612,017.41 | -16,055,707.23 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 335,385,196.26 | 381,535,592.74 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,870,396.26 | 2,285,400.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,870,396.26 | 2,285,400.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,870,396.26 | 2,285,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,870,396.26 | 2,285,400.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 2,000,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 327,514,800.00 | 379,250,192.74 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,760,000.00 | 10,926,492.74 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,760,000.00 | 3,894,669.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 7,031,823.74 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 321,754,800.00 | 368,323,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 321,754,800.00 | 368,323,700.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 335,385,196.26 | 381,535,592.74 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 335,385,196.26 | 381,535,592.74 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 308,569,525.00 | 363,360,509.19 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 177,597,200.00 | 207,330,495.00 |
| 210101 | Үндсэн цалин | 140,787,500.00 | 164,127,695.00 |
| 210102 | Нэмэгдэл | 36,809,700.00 | 43,202,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,288,586.00 | 26,071,727.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,171,107.00 | 17,696,972.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,779,400.00 | 2,092,528.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,423,500.00 | 1,675,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 355,893.00 | 418,127.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,558,686.00 | 4,188,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52,998,031.00 | 53,214,114.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,045,174.00 | 6,236,114.00 |
| 210302 | Түлш, халаалт | 49,952,857.00 | 46,978,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,432,120.00 | 32,027,940.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,427,200.00 | 4,347,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,554,920.00 | 23,135,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 895,000.00 | 1,138,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 156,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 255,000.00 | 3,249,990.00 |
| 2105 | Нормативт зардал | 00.00 | 340,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 340,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,477,000.00 | 200,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 200,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,277,000.00 | 00.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,854,000.00 | 1,342,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,854,000.00 | 1,342,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 4,000,000.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,822,588.00 | 22,727,263.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,200,588.00 | 19,125,063.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 18,000.00 | 17,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 21,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,100,000.00 | 20,106,970.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,000,000.00 | 19,106,970.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,100,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,815,671.26** | **18,175,083.55** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,990,700.00 | 12,140,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,590,700.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,400,000.00 | 12,140,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,824,971.26 | 6,035,083.55 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,706,477.00 | 3,459,419.81 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 545,016,013.96 | 93,767,282.48 | 555,830,594.99 | 1,194,613,891.43 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **545,016,013.96** | **93,767,282.48** | **555,830,594.99** | 1,194,613,891.43 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | -1,495,000.00 | 00.00 | -1,495,000.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 151,614,017.41 | 151,614,017.41 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **707,442,612.40** | 1,344,730,908.84 |
| D01 | **2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **707,442,612.40** | 1,344,730,908.84 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **707,442,612.40** | 1,344,730,908.84 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -16,055,707.23 | -16,055,707.23 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,016,013.96** | **92,272,282.48** | **691,386,905.17** | 1,328,675,201.61 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 368,323,700.00 | 365,864,280.19 | 2,459,419.81 | 99.3% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 368,323,700.00 | 365,864,280.19 | 2,459,419.81 | 99.3% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 356,178,700.00 | 353,724,280.19 | 2,454,419.81 | 99.3% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 207,431,900.00 | 207,330,495.00 | 101,405.00 | 100.0% |
| 210101 | Үндсэн цалин | 164,229,100.00 | 164,127,695.00 | 101,405.00 | 99.9% |
| 210102 | Нэмэгдэл | 43,202,800.00 | 43,202,800.00 | 0.00 | 100.0% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,583,400.00 | 26,071,727.19 | 511,672.81 | 98.1% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,206,000.00 | 17,696,972.19 | 509,027.81 | 97.2% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,094,400.00 | 2,092,528.00 | 1,872.00 | 99.9% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,675,500.00 | 1,675,500.00 | 0.00 | 100.0% |


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 418,900.00 | 418,127.00 | 773.00 | 99.8% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,188,600.00 | 4,188,600.00 | 0.00 | 100.0% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,223,500.00 | 53,214,114.00 | 9,386.00 | 100.0% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,245,400.00 | 6,236,114.00 | 9,286.00 | 99.9% |
| 210302 | Түлш, халаалт | 46,978,100.00 | 46,978,000.00 | 100.00 | 100.0% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,839,400.00 | 31,601,940.00 | 237,460.00 | 99.3% |
| 210401 | Бичиг хэрэг | 3,924,800.00 | 3,921,550.00 | 3,250.00 | 99.9% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,165,500.00 | 23,135,900.00 | 29,600.00 | 99.9% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,139,100.00 | 1,138,000.00 | 1,100.00 | 99.9% |
| 210404 | Ном, хэвлэл | 360,000.00 | 156,500.00 | 203,500.00 | 43.5% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,250,000.00 | 3,249,990.00 | 10.00 | 100.0% |
| **2105** | **Нормативт зардал** | 340,000.00 | 340,000.00 | 0.00 | 100.0% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 340,000.00 | 340,000.00 | 0.00 | 100.0% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.0% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,348,300.00 | 1,342,000.00 | 6,300.00 | 99.5% |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,348,300.00 | 1,342,000.00 | 6,300.00 | 99.5% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,100,500.00 | 13,517,034.00 | 1,583,466.00 | 89.5% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,478,500.00 | 9,914,834.00 | 1,563,666.00 | 86.4% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 18,000.00 | 17,000.00 | 1,000.00 | 94.4% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40,000.00 | 21,200.00 | 18,800.00 | 53.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564,000.00 | 3,564,000.00 | 0.00 | 100.0% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20111700.00 | 20106970.00 | 4,730.00 | 100.0% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,111,700.00 | 19,106,970.00 | 4,730.00 | 100.0% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12145000.00 | 12140000.00 | 5,000.00 | 100.0% |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,145,000.00 | 12,140,000.00 | 5,000.00 | 100.0% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,145,000.00 | 12,140,000.00 | 5,000.00 | 100.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 368,323,700.00 | 365,864,280.19 | 2,459,419.81 | 99.3% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 367,323,700.00 | 364,864,280.19 | 2,459,419.81 | 99.3% |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 367,323,700.00 | 364,864,280.19 | 2,459,419.81 | 99.3% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0% |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0% |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0% |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 0.00 | 100.0% |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 20.00 | 20.00 | 0.00 | 100.0% |
| 620001 | Удирдах ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0% |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **20.00** | **20.00** | 0.00 | 100.0% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0% |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨВШИЛЦСӨН ТӨЛӨВЛӨГӨӨ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.00 | 100.0% |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07.00 | 07.00 | 0.00 | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,430,396.26** | **10,926,492.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,430,396.26** | **10,926,492.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,311,902.00 | 8,350,829.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,311,902.00 | 8,350,829.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,311,902.00 | 8,350,829.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1118494.26 | 2575663.74 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,118,494.26 | 2,575,663.74 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,118,494.26 | 2,575,663.74 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 12430396.26 | 10926492.74 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,430,396.26 | 10,926,492.74 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,760,000.00 | 3,894,669.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,670,396.26 | 7,031,823.74 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ~~Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын~~ дарга Б.Өнөрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Жаргалант сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 1а/182 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Төрийн захиргааны нэгдмэл удирдлагыг хангаж, төрийн мэргэшсэн албан хаагчаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхайн үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй мэдээлж хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд Жаргалант сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 398557.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7971.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 548937.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10978.8 мянган төгрөгөөр тооцов.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жаргалант сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1328678.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 16053.6 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 88,194.7 | 88,106.6 | (88.1) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 5.3 | 26.0 | 20.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 88,189.5 | 88,080.6 | (108.8) |

| | | | |
|---|---|---|---|
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,256,537.2 | 1,240,571.7 | (15,965.5) |
| Үндсэн хөрөнгө | 1,759,824.0 | 1,884,936.5 | 125,112.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | (503,286.8) | (644,364.8) | (141,078.0) |
| **Нийт хөрөнгө** | 1,344,731.9 | 1,328,678.3 | (16,053.6) |
| Өр төлбөр | 1.0 | 3.1 | 2.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,344,730.9 | 1,328,675.2 | (16,055.7) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,344,731.9 | 1,328,678.3 | (16,053.6) |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

2020 онд цалингийн нэгдсэн программд орсонтой холбогдуулан тооцооллын зөрүү гарснаас 20,7 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, 3.1 мянган төгрөгийн цалингийн өглөгтэй гарчээ. Цаашид цалингийн тооцооллыг үнэн зөв бодож, өглөг, авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.

Бараа материалын дансны үлдэгдэл 88080.6 мянган төгрөг болж 108.8 мянган төгрөгөөр буурсан нь Жаргалант сумын ЗДТГ-ын даргын 2020.12.25-ны өдрийн А/64 тоот тушаалаар 4445.8 мянган төгрөгийн материал, малын эмчийн актыг үндэслэн 1170.0 мянган төгрөгийн хорогдсон малыг акталсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1884936.5 мянган төгрөг болж 125112.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ИТХ-ын 2021.01.18-ны өдрийн 07 тоот тогтоолыг үндэслэн аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийлүүлсэн Ланд 105 суудлын автомашин 40000.0 мянга, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 78200.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг сумын ИТХ-ын 2021.01.14-ны өдрийн 02 тоот тогтоолыг үндэслэн хөрөнгөд үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, 4492.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн ЗДТГ-аас шилжүүлэн авсан, төсвийн хөрөнгөөр 2419.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот "Дутагдсан болон маргаантай хөрөнгийн талаар авах арга хэмжээний тухай" захирамжаар тус байгууллагад хуучин цахилгаан станцын барилгыг иргэн Ц.Гантөмөрт шилжүүлсэн байсныг Жаргалант сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.12.17 өдрийн 36 тоот тогтоолоор 1306.9 мянган төгрөгийн хуучин цахилгаан станцын барилгыг хөрөнгөд орлогоор бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1328675.2 мянган төгрөг болж 16055.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 16055.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 532882.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 95511.3 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар буурсан байна.

Энэ нь төсөвт байгууллагын үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 141661.7 мянга, туслах үйл ажиллагааны орлого 3585.0 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих 2000.0 мянган төгрөгөөр буурч, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 46568.9 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан санхүүжилт 5166.5 мянган төгрөгөөр өмнөх оноос өссөнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 553873.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 91115.7 мянган төгрөгөөр буюу 19.67 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 31277.6 мянга, НДШ 4282.9 мянга, хангамж бараа материалын зардал 36229.4 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 2084.1 мянга, хангамж, бараа материалын зардал 53216.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 27800.5 мянган төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 430500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 430500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 363052.0 мянган төсөв батлагдаж 2 удаа тодотгол хийн 368323.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 367323.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, өөрийн орлогоор 1000.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 368323.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 2285.4 мянган төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 365864.3 мянган төгрөгийг зарцуулж 3459.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 365864.3 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа цалин 101.4 мянга, НДШ-511.7 мянга, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр 1583,5 мянга, хангамж, бараа материалын данс 237.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

| Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| НИЙТ | | | | | |
| Хөтөлбөр70106 | ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | 368,323,700.00 | 365,864,280.19 | 2,459,419.81 | 99.3% |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 278,574,800.00 | 276,954,068.00 | 1,620,732.00 | 99.4% |
| АРГА ХЭМЖЭЭ 80106 | Баг, хорооны ҮАЗардал | 50,803,900.00 | 50,137,342.19 | 666,557.81 | 98.7% |
| АРГА ХЭМЖЭЭ 80305 | Биеийн тамирын уралдаан, тэмцээн | 5500000 | 5,500,000.00 | 0.00 | 100.0% |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 11,745,000.00 | 11,740,000.00 | 5,000.00 | 100.0% |
| АРГА ХЭМЖЭЭ 81102 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 11,700,000.00 | 11,696,370.00 | 3,630.00 | 100.0% |
| АРГА ХЭМЖЭЭ 82212 | Хур хог хаягдал, орчны бохирдол | 10,000,000.00 | 9,836,500.00 | 163,500.00 | 98.4% |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар мал тооллого 676.0 мянга, нийгмийн түншлэлийн зардал 2000.0 мянга, өмнөх оны үлдэгдэл 1418.5 мянга, хог ачилтын мөнгө 1230.8 мянга, ард иргэдээс 5160.0 мянган төгрөгийн хандив орсноос 8350.8 мянган төгрөгийг зарцуулж 2575.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 8 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс санхүүжилтийн 212068.0 мянган төгрөгийн 15 мэдээлэл байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд санхүүгийн тайланд аудит хийгдээгүй болно.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28745.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28745.5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 23292.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Илрүүлэлт1:Тайлант онд Сум дундын ойн ангиас 24499.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг хүлээн авч борлуулж 18448.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч Сум дундын ойн ангиас ирүүлсэн тооцоогоор 6051.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байхад тооцоо нийлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалт, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

<u>**Шийдвэрлэсэн нь**</u>: Сум дундын ойн ангиас олгосон өвс тэжээлийн тооцоог 2021.03.15-ны дотор нийлж, үлдэгдэл тооцоог баталгаажуулан данс бүртгэлд тусган биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт2:Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 2500.0 мянган төгрөгийн хүлэмжийн эзэн холбогдогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй, мөн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 20194.5 мянган төгрөгийн үнэтэй 5 багт хийсэн бэлчээрийн хайс байгаа эсэх нь тодорхой бус байна

<u>**Шийдвэрлэсэн нь**</u>:

Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг бүрэн хэрэгжүүлж дутсан хөрөнгөтэй холбоотой асуудлыг холбогдох шилжүүлэх, байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн 20194.5 мянган төгрөгийн үнэтэй 5 багт хийсэн бэлчээрийн хайсын асуудлын сумын ИТХ-аар хэлэлцүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт2. Тайлант хугацаанд Шилэн дансны сайтад оруулбал зохих 149 мэдээллээс 8 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс санхүүжилтийн 212068.0 мянган төгрөгийн 15 мэдээлэл байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u> Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

мэдээлнэ" гэсний дагуу батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж байна.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. *Балансын данстай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* ЗДТГ-т хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжуудын газрын эзэмших гэрчилгээ гараагүй байгаа нь Газрын тухай хуулийн 23.6.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.3-т заасан эрхийн улсын бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. *Эрсдэл*: Хөрөнгө үрэгдэх

1.3. *Өгсөн зөвлөмж:* Газрын тухай хуулийн 23.6.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал нь газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.3-т заасан эрхийн улсын бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ" гэсэн заалтын дагуу ЗДТГ-т хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжуудын газар эзэмших гэрчилгээ гаргуулах

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР М.АЛТАНТУЯА 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.25



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Жаргалант сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/113/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Жаргалант сумын ЗДТГ | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант онд Сум дундын ойн ангиас 24499.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг хүлээн авч борлуулж 18448.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч Сум дундын ойн ангиас ирүүлсэн тооцоогоор 6051.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байхад тооцоо нийлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна. | 6051.0 | Албан шаардлага хүргүүлэх | Дарга, нягтлан бодогч | Б.Өнөрбаяр Д.Баттөр |
| 2 | Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 2500.0 мянган төгрөгийн хүлэмжийн эзэн холбогдогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй, мөн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 20194.5 мянган төгрөгийн үнэтэй 5 багт хийсэн бэлчээрийн хайс байгаа эсэх нь тодорхой бус байна. | 22694.5 | Албан шаардлага хүргүүлэх | Дарга, нягтлан бодогч | Б.Өнөрбаяр Д.Баттөр |
| 3 | Тайлант хугацаанд Шилэн дансны сайтад оруулбал зохих 149 мэдээллээс 8 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнээс санхүүжилтийн 212068.0 мянган төгрөгийн 15 мэдээлэл байршуулаагүй байна. | 0 | Албан шаардлага хүргүүлэх | Дарга, нягтлан бодогч | Б.Өнөрбаяр Д.Баттөр |
| 4 | ЗДТГ-т хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжуудын газрын эзэмших гэрчилгээ гараагүй байна | 0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Б.Өнөрбаяр Д.Баттөр |
| **ДҮН** | | **28745.5** | | | |

___________oOo_________



095 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ